БАТЛАВ.
НИЙСЛЭЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Д.БАТ-ӨЛЗИЙ

2025 оны 11. дугаар сарын 14

ЖИЖИГ ГОЛ, ГОРХИНЫ ЭХ, ТАТМЫГ ОЙЖУУЛАХ ЗАМААР ОЙ БҮХИЙ ТАЛБАЙН ХЭМЖЭЭГ НЭМЭГДҮҮЛЖ ОЙН ЗУРВАС БАЙГУУЛАХ АЖЛЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Дугаар:01

2025 оны 04 сарын 14 өдөр Улаанбаатар хот

	Шалгуур
Ойн зурвас байгуулах ажил гүйцэтгэх аж ахуйн нэгж, байгууллагыг сонгон шалгаруулахад харгалзах үзүүлэлтүүд	Ойн мэргэжлийн байгууллагын гэрчилгээтэй байх. */мод үржүүлэх, ойжуулах ойг нөхөн сэргээх зөвшөөрөл/*
	Ойн зурвас байгуулах ажил хийх мэргэжлийн боловсон хүчинтэй байх */тэдгээрийг баталгаажуулах/* байгууллагадаа 2-оос доошгүй жил ажиллаж, нийгмийн даатгалын төлөлт хийгдсэн байх. */Үндсэн-Ойн инженер, ХАБЭА-н инженер-гэрээт/*
	Ойн зурвас байгуулах ажилд шаардлага хангасан стандартын тарьц, суулгацын нөөцтэй байх “Стандартын шаардлага хангасныг нотлох баримт, МҮГ-ын гэрчилгээ, кадастрын зургийн хамт ирүүлэх. /MNS6141:2020 Навчит модны суулгац. Техникийн шаардлага/”
	Сүүлийн 3 хүртэлх жилийн хугацаанд гүйцэтгэсэн ажлын жагсаалт, тэдгээрээс гүйцэтгэсэн ижил төстэй ажлын өртөг, хугацаа, байршил, бүрэн гүйцэтгэсэн болохыг тодорхойлсон өмнөх үйлчлүүлэгчийн тодорхойлолт; */2022, 2023, 2024 он тус бүрд хийсэн ажлын гэрээ, акт, гэрээ дүгнэсэн протокол, ажлын хэсгийн тэмдэглэл хавсаргах/*
	1 га талбайд ойн зурвас байгуулах ажилд стандартын шаардлага хангасан 3-4 настай навчит модны 1200 ширхгээс доошгүй суулгац байхаар тусгах;
	Ойн зурвас байгуулах ажилд шаардлагатай ажлын багаж, хэрэгсэл, техник тоног төхөөрөмжийн талаарх мэдээлэл ирүүлэх */баталгаажуулах/*;
Бэлтгэл ажил	Ойн зурвас байгуулах ажилд хэрэглэгдэх техник тоног төхөөрөмжүүдийн техник үйлчилгээг бүрэн хийн ажилд гарахад бэлэн болгох;
	Ойн зурвасын ажлын технологийн карт, дараалал боловсруулан ажилчдад танилцуулах, мөрдөх; */технологийн дарааллын загварыг хавсаргав/*
	Ойн зурвас байгуулах ажлыг гүйцэтгэх улирлын болон түр ажилчдад ажил гүйцэтгэх технологи болон хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаар зааварчилгаа бэлтгэх, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх талаар анхааруулга өгөх; “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн зааварчилгаа” MNS4969:2000
	Ойн зурвас байгуулах талбайг цэвэрлэх */чулуу болон бусад зүйлсийг цэвэрлэх шаардлагатай үед/*, талбай тусгаарлах, тэмдэг тавих, өнцгүүдэд шон босгох;
	Суулгацыг тээвэрлэх, суулгах үед үндэсний систем хатахаас

	хамгаалах арга хэмжээ авах, хадгалах нүх шуудуу бэлдэх; Хөл газрын ургамлыг устгах хөрсийг сийрүүлэх */Тарьцыг хөнөөлт шавж, өвчнөөс хамгаалах/*;
	Ойр орчмын иргэдэд мал бэлчээхийг хориглох талаар танилцуулга, уулзалт зохион байгуулах;
Ойн зурвас байгуулах	"Навчит модны суулгац. Техникийн шаардлага" MNS6141:2020, "Улиасны суулгац. Ерөнхий шаардлага" MNS6257:2011 стандартуудад нийцсэн суулгацуудыг ойн зурвас байгуулах ажилд хэрэглэх, баталгаажуулсан технологийн картын дагуу тарилт хийх; "Суулгацын нүхийг бэлтгэх, суулгах. Ерөнхий шаардлага" MNS6258-1:2011 стандартын дагуу суулгацын нүхийг бэлтгэнэ.
	Ойн зурвасын талбайн байршил хавсралт 1;
	Ойн зурвасд мод тарилтыг 5 дугаар сарын 10-наас 6 дугаар сарын 10-ны хооронд хийх, шаардлагатай үед нөхөн тарилтыг 9 дүгээр сарын 25-наас 10 дугаар сарын 10-ны өдрийн хооронд хийх;
	Ойн зурвас байгуулах талбайн зураглал боловсруулах, мэдээллийн самбар байршуулах;
	Тарилтын схем: Эгнээ хооронд 4 метр, мод хооронд 2 метр, 1 га талбайд 1200 ширхэгээс доошгүй байхаар тооцох, нүхний өргөн 20-60 см, 40-60 см гүнд тарилтыг хийх;
	Усалгаа хийх автомашин талбайд нэвтрэхэд зориулж 3-3,5 метрийн өргөнтэй хаалга гаргасан байна.
	Тарьсан суулгацыг арчлах, гаднын хүчин зүйлээс хамгаалах, тогтмол усалгааны ажил гүйцэтгэх. "Мод сөөгний суулгац арчлах" MNS6258-2:2011
Талбайг хүлээлгэн өгөх.	Ойн зурвас байгуулсан талбайг захиалагч байгууллагаас томилогдсон ажлын хэсэг, тухайн газар нутгийг хариуцсан байгаль хамгаалагчид хяналт тавьж 75 хувиас дээш амьдралтын хувьтай тохиолдолд актаар хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулна.
Зөрчил, гологдол арилгах.	Суулгасан суулгац нь 50-74,9 хувийн амьдралтай ургасан бол гүйцэтгэгч өөрийн зардлаар 90 хувь хүртэл нөхөн тарилт хийж, актаар хүлээлгэн өгнө. Суулгасан суулгац нь 25-49,9 хувийн амьдралтай ургасан бол гүйцэтгэгчид урьдчилгаагаар олгосон норматив зардалд хүрэхүйц шаардлагатай нөхөн тарилтыг гүйцэтгэгчийн хөрөнгөөр хийлгэж дараа жилийн намар хүлээж авна. Суулгасан суулгац нь 24,9 хүртэл хувийн амьдралтай тоологдсон тохиолдолд уг ажлыг хангалтгүй гүйцэтгэсэн гэж үзэж гүйцэтгэгчээр ойжуулалтын ажлын урьдчилгааг эргүүлэн төлүүлнэ.
Тайлан боловсруулах	Ойн зурвас байгуулсан ажлын тайланг захиалагчид 3 хувь ирүүлнэ. Тайлан дор дурдсан бүрдэл хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд: а/ "Ойн зурвас байгуулах ажил гүйцэтгэсэн тайлан"; б/ 1:50000-ны масштабтай ойн зурвас байгуулсан талбайн зураг;
	а. "Ойн зурвас байгуулах ажил гүйцэтгэсэн тайлан"-д: Ойн зурвас байгуулсан ажлын үе шат тус бүрээр хийсэн ажлын гүйцэтгэл, ажлын технологийн дараалал, тарилтын схем, тарьц, суулгацын стандартын шаардлага хангасан байдал, ажил гүйцэтгэсэн хугацаа, ажиллах хүчин, ажлын өдөр тутмын гүйцэтгэл, тавьсан хяналт зэрэг мэдээллийг

	багтаана. Дээж талбайн тооллого болон бусад судалгааны ажлын үед авсан гэрэл зураг, ойн төлөв байдлын зураг, ойн зурвасын ерөнхий байдлын зураг, эхлэл төгсгөлийн зургийг харьцуулсан байдлаар фото хэлбэрээр, санхүүгийн гүйцэтгэлийг тус тус тайланд хавсаргана. **б."Ойн зурвас байгуулах ажил явуулсан талбайн зураг"-т:** Талбайн хилийн солбицол, дугаар, талбайн хэмжээ, газрын төрлийн ангилал тэмдэглэгээ, модны төрөл, насны бүлэг, газар ус, уул, өндөрлөг тоотын нэр , газар зүйн байрлалын солбицлын торлол, зургийн масштаб, проекц, таних тэмдэг эдгээрийг ой зохион байгуулалтын технологийн зааварт заасан стандартын дагуу гүйцэтгэж оруулна. **в.** Тайланг захиалагч байгууллагаас томилогдсон ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлэн хүлээлгэн өгнө. Хэрэв тайланд зөрчил гологдол илэрсэн бол түүнийг арилгах үүргийг гүйцэтгэгч хүлээнэ. Зөрчил гологдлыг арилгасан тухай төслийн менежер мэдэгдэл гарган дахин хурлаар хэлэлцүүлэн хүлээн авсны дараа эцсийн шатны санхүүжилтийг олгоно. Зураг боловсруулалтын ажлыг Засгийн газрын 2009 оны 1-р сарын 28-ны өдрийн 25-р тогтоолын дагуу олон улсын WGS-84 солбицлын систем, өндрийн сүлжээний Балтийн тэнгисийн тогтолцоог, том дунд масштабын байр зүйн зураглалд дэлхийн хөндлөн меркаторын UTM (UNIVERSAL TRANSVERS MERCATOR) тусгагийг хэрэглэнэ. Ойн зурвас байгуулах ажлын тайлан болон зургийн shp.файлуудыг цахим хэлбэрээр 1 хувь ирүүлнэ.
Тайланг хэлэлцүүлэн хүлээлгэн өгөх	Ойн зурвас байгуулсан ажлын тайланг Нийслэлийн Байгаль орчны газарт хоёр хувийг хүргүүлнэ. Тайланг зөвшөөрөх хугацааг ажлын үе шатны хуваарьт тусгасан байна. Тайланг нээлттэйгээр хэлэлцүүлнэ.
Усалгаа, хамгаалалт, нөхөн тарилт хийх.	Ойн зурвас байгуулсан талбайгаа 3 жилийн хугацаанд арчлан хамгаалж ургуулах бөгөөд энэ үзүүлэлтийг дараагийн ажил гүйцэтгэх гэрээ байгуулахад нэг шалгуур үзүүлэлт болгоно. Шаардлагатай үед нөхөн тарилт хийх, хашаа хамгаалалтыг сэргээх, ойн зурвасын талбайд тарилт хийхдээ бороо угтуулах, тарьсны дараах усалгааг заавал хийх талаар тусгах, түймэр хөнөөлт шавжаас хамгаалах арга хэмжээ зохион байгуулах, хөл газрын ургамалтай тэмцэх, хөрс сийрүүлэх зэрэг арга хэмжээг 3 жилийн хугацааны турш хийж гүйцэтгэнэ.
	Хамгаалалтын хашааны загвар хавсралт 2; */840 метр хашаа барих/*
	Уулын налуу болон жалгын ховилоор хашаан доогуур жижиг мэрэгч амьтан болон мал орохоос сэргийлэх жижиг тор татах;
	Хамгаалалтын ойн зурвас байгуулсан талбайг арчлах ажлын зардлын тооцоо хавсралт 3;

Хянасан: Ч.Мөнхбаяр
Ойн хэлтсийн дарга

Боловсруулсан: Г.Нацаг
Ойн хэлтсийн мэргэжилтэн

Нийслэлийн Байгаль орчны газрын
даргын 2025 оны .4 дүгээр сарын 14-ны өдрийн
“жижиг гол, горхины эх, татмыг ойжуулах замаар
ой бүхий талбайн хэмжээг нэмэгдүүлж
ойн зурвас байгуулах” хавсралт 1

ТУЗ3223 9077049

ХАМГААЛАЛТЫН ОЙН ЗУРВАС БАЙГУУЛАХ БАЙРШИЛ, ХИЛИЙН ЦЭС



Улаанбаатар хотын ногоон бүсийн Дэндийн амны байгаль хамгаалагчийн хариуцан хамгаалах ойн сангийн ОЙН ТАРХАЛТЫН ЗУРАГ

Хэсэгпэлийн дугаар: 152, 157, 157, 171, 172, 177, 178, 183, 184, 185, 194
Ойн сангийн талбай: 5908 га
Зургийн проекц: WGS_1984_UTM_Zone_48N

ТАНИХ ТЭМДЭГ



Нийслэлийн Байгаль орчны газрын
даргын 2025 оны 11 дүгээр сарын 14-ны өдрийн
“жижиг гол, горхины эх, татмыг ойжуулах замаар
ой бүхий талбайн хэмжээг нэмэгдүүлж
ойн зурвас байгуулах” хавсралт 2

ХАМГААЛАЛТЫН ТӨМӨР ТОРОН ХАШААНЫ ШААРДЛАГА

Нийслэлийн нутаг дэвсгэрт ойжуулалт, ойн зурвас, нөхөн сэргээлтийн ажлын чанарыг сайжруулахад удаан эдэлгээтэй, чанарын шаардлага хангахуйц хамгаалалтын хашаа барих шаардлагатай.

Хамгаалалтын төмөр торон хашааны хийцийг доорх хүснэгтээр үзүүлэв (Хүснэгт 1).

№	Материал	Зураг	Тодорхойлолт
1	Төмөр болон шахмал хуванцар шон		• Төмөр хийцтэй хашааны шонгийн диаметр 40 мм-ээс багагүй, • Шахмал хуванцар шонгийн диаметр нь 10 см-ээс багагүй байх (шонгийн нийт урт 2 м)
2	Хашааны төмөр тор		• Хашааны торны нүхний хэмжээ 6 см*6 см-ээс ихгүй, 1.5 м өндөртэй, төмөр утасны бүдүүн 6 мм-ээс багагүй байх • Хашааны шон хоорондын зай 3 м-ээс ихгүй байх

3	Төмөр утас		• Хашааны дээд, дунд, доод хэсгээр 3 мм-ээс багагүй бүдүүнтэй төмөр утас эсвэл өргөст тороор чангалж бэхлэх
4	Бэхэлгээ хийх арга, материал		• Хашааны өнцгийн шонд дотор талаас нь тулаас хийж, гадна талаас нь төмөр утсаар татаж, чангалан бэхлэх
5	Шон суулгах нүхний хэмжээ, орох материал		• Шонгийн нүхийг 50 см гүн ухаж, 20 см-аас багагүй диаметртэй, 0.5-1.0 см хэмжээтэй хайрга бүхий цементэн зуурмагаар дүүргэж, чигжинэ.

Нийслэлийн Байгаль орчны газрын
даргын 2025 оны 4 дүгээр сарын 14-ны өдрийн
“жижиг гол, горхины эх, татмыг ойжуулах замаар
ой бүхий талбайн хэмжээг нэмэгдүүлж
ойн зурвас байгуулах” хавсралт 3

ХАМГААЛАЛТЫН ОЙН ЗУРВАС БАЙГУУЛСАН ТАЛБАЙГ АРЧЛАХ АЖЛЫН ЗАРДЛЫН ТООЦОО

Хамгаалалтын ойн зурвас байгуулсан талбайн арчилгааны ажлын зардалд нөхөн тарилтын, усалгааны, цалин, НДШ, томилолтын зэрэг зардал.

д/д	Зардлын төрөл	1 га талбайд зарцуулагдах зардлын хэмжээ /төгрөг/
1	Нөхөн тарилтын зардал	3,600,000.00
2	Цалин, НДШ	656,000.00
3	Томилолт	1.908,000.00
4	Усалгааны зардал	2,616,000.00
ДҮН		**8,780,000.00**

Нөхөн тарилтын зардал тооцсон аргачлал. Нийт ойн зурвас байгуулсан талбайн 25 хувьд нь нөхөн тарилт хийнэ. Ойн зурвас байгуулах үед 1 га талбайд 1200 ширхэг суулгац суулгадаг бөгөөд 25 хувь нь буюу 300 ширхэг суулгац суулгана. Энд 300 ширхэг суулгац суулгах зардлыг 2 жилээр тооцсон.